

## НОМЫН ШҮҮМЖ, МЭДЭЭЛЭЛ, ТАНИЛЦУУЛГА

**ЕРТӨНЦИЙГ БАЙЛДАН ДАГУУЛАГЧ ЧИНГИС ХААН  
ТҮҮНИЙ ҮР САД  
(Номын шүүмж)**

Д.Эрдэнэ-Отгон\*

БНХАУ-ын түүхч Ян На "Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх" нэртэй ном бичиж 1997 оны 1 сард Бээжинд хэвлүүлжээ. 7 бүлэг 146 хуудастай энэ зохиол нь урьд өмнө Хятадад Монголын тулгуур төр, Чингисийн талаар гарч байсан ном зохиолыг бодвол нэлээд шинэлэг үзэл санаагаар бичигдсэн мэт байна. Өөрөөр хэлбэл, Их Монгол Улсын талаар баримталж ирсэн Хятадын түүхчдийн үзэл санаа өөрчлөгдөж байгаа юмуу гэлтэй. Зохиолын 1-р бүлэгт Монголын тулгар төр байгуулагдсан тухай, 2-р бүлэгт Чингисийн аян дайн /1207-1227/, гуравдугаар бүлэгт Өгөдэйн аян дайн /1230-1241/, 4-р бүлэгт Мөнхийн аян дайн /1251-1259/, 5-р бүлэгт Хубилайн явуулсан аян дайн /1260-1293/, 6-р бүлэгт Чингис хаан ба түүний үр садын тухай, 7-р бүлэгт Чингис хааны байгуулсан тулгуур төрийн тухай зохиогч өөрийн үзэл санааг илэрхийлжээ.

Номын ихэнх хуудсыг эзлүүлэн Чингис, Өгэдэй, Мөнх, Хубилай дөрвөн хааны байлдан дагуулалыг л голчлон авч бичсэн байна. Тэгэхдээ монголын дөрвөн их хаадын явуулсан дайны ажиллагааг түүхэн сурвалжийн баримтанд тулгуурлан сүрхий бодитойгоор дүгнэхийг хичээсэн тал харагдаж байна.

Зохиолын нэгдүгээр бүлгийн "Монгол улс байгуулагдсан" гэдэг 2-р зүйлд: Чингис хаан байгуулсан улсаа "Их Монгол" гэж нэрлэсэн .... Монгол гэдэг нэр нийт монголчуудын нэгэн нийтлэг нэр болон хэвшсэн .... Их Монгол улс байгуулагдсаны дараа эргэн тойрны улс орнууд тэднийг "Монгол", "Татар" гэдэг хоёр нэрээр дуудан нэрлэж байсан. Иймээс Хятадын түүх сударт "Монгол-татар" гэж бичигдсэн байдаг юм. гэх мэтээр бичжээ.

Мөн Чингис хаан дуугарвал дуу нэг гэдэг зарчмаар хэлсэн үгэндээ заавал хүрдэг. Гаргасан зарлигаа заавал биелүүлдэг, хуулийг чанга баримтлан, хууль үл сахигчдыг хатуу цээрлүүлэн шийтгэдэг байсан талаар дэлгэрэнгүй бичжээ.

Чингис архи уудаггүй шахам, уусан ч тохируулж бага хүртдэг байсан хаан гэнэ, тэгээд ч тэрээр архи хэрэглэвээс гурван хундагаас илүү ууж болохгүй, хоёр хундага уувал сайн, нэг хундага уувал бүр сайн, огт уухгүй бол үнэнхүү сайн гэж ярьдаг байсанг Рашид-ад-Дины зохиол дотроос онцлон түүвэр ишлэл татаж өгүүлжээ.

Тэр ч байтугай монголчууд их эзэн хааныхаа сургаалыг одоо ч гэсэн дагах ёстой биш билүү гэдэг санааг гарган тавьжээ. Чухам ингэж энэ эрдэмтэн монголчууд биднийг архи бага хэрэглээрэй гэж л тойруу замаар захин бичсэн мэт харагдана.

Их Монгол Улсын гурван хаан (Чингис, Өгөдэй, Мөнх) болон Юан гүрний анхдагч хаан Хубилайн удирдан хийсэн аян дайны ажиллагааг харь улсыг түрэмгийлсэн дайн гэдэг утгаар авч бичихдээ голдуу хятад, перс хэлний сурвалж түшиглэжээ. Тэгэхдээ түрэмгий дайн байсан гэдэг талаас нь авч бичсэн байна. Тэр үед дайтсан улс орнууд нь заримдаа дайныг эхлэн өдөөсөн, Чингисийн тулган шаардлагыг хүлээн аваагүйгээс үүссэн, бас хил хязгаараа хамгаалах чанартай байсан зэрэг шалтгааныг үнэн мөнөөр нь

\* Д.Эрдэнэ-Отгон. Зүүн хойт Ази судлалын төвийн эрдэм шинжилгээний дэд ажилтан

өгүүлсэн байна. Эдгээр дайнуудын явцыг уул зохиолоос уншин ажиглахад Их Монгол улсаас харь улс оронд аян дайн хийж, бусдын газар нутагт, түрэмгийлэн халдаж байсан түрэмгий дайн гэдэг санаа гарч байна. Үүнээс өмнө Хятадын зарим түүхчид Их Монгол Улсын хаадаас Алтан улс, Тангад улс, Өмнөд Сүн улстай хийсэн дайныг "Дотоодын дайн" гэж бичдэг байсан. Гэтэл эрдэмтэн Ян На тийм үзэл бодлын эсрэг зогсжээ.

Зохиолын 146-р талд: 13-р зууны үеийн "Монголын нууц товчоо" зэрэг монгол сурвалжид монголчууд өөрсдийнхөө байгуулсан улсаа "Их Монгол Улс" гэж нэрлэсэн ... Харин Алтан улс, Тангад улс, Өмнөд Сүн улс болон Хорезм, Оросыг харь (гадаад) улс гэж нэрлэжээ...

Чингис хаан дорно, өрнө зүг хийсэн дайнаа адилханд үзэж байсан ... Өнөөдөр хэдийгээр монгол үндэстэн БНХАУ-ын гэр бүлийн эрх тэгш нэгэн гишүүн болон явж байгаа ч гэсэн энэ нь Чингисийн байгуулсан Их Монгол улсаас хойших түүхэн нөхцөл, эсдрээтэй цаг үеийн учир шалтгаан болсон үйл явдлаас болсон юм... Хятадын түүхчид бид хүний өөрийн түүхийг үнэн зөв бодитойгоор сэтгэж энэ талаар үзэл санаагаа нэгтгэх цаг болсон гэх мэтээр бичжээ.

Энэчлэн шинэлэг санаа эрдэмтэн Ян На-гийн зохиолд их байна. Ялангуяа Чингис хааны түүхэн роль үүргийн талаар урьд өмнө нь дэлхий дахинд гарч байсан өрөөсгөл дүгнэлтийг шүүмжлэн Чингис хаан зөвхөн түрэмгий дайн хийдэг хүн биш, тэрээр монголоор зогсохгүй дэлхийн түүхэнд асар том үүрэг гүйцэтгэсэн Монгол үндэстний бахархал төрүүлсэн ухаант удирдагч байсан юм гэх мэтээр бичжээ. Чингисийн роль үүргийг дэлхийн хоёр нэг төрийн зүтгэлтэн юм уу эсвэл хэдхэн эрдэмтэн үнэлэн тогтоох асуудал огт биш... Түүнийг үнэн зөв үнэлэхийг монголчууд ялангуяа БНМАУ-д ард түмэн зүтгүү үүрэг гүйцэтгэх учиртай гэх мэтээр бас бичжээ.

1962 онд Чингис хааны мэндэлсний 800 жилийн ойгоор Хятад, Орос, Монгол гурван улсын эрдэмтэн Чингис хааны талаар өөрсдийн үзэл бодлоо илэрхийлж олон өгүүлэл бичиж үзэл бодлоо уралдуулсныг өгүүлжээ. Тэд бүгдээрээ л өөр өөр бодол санаатай байсан ... Хэнийх нь зөв болохыг түүнээс хойших 30 гаруй жилийн түүхийн явц харуулж өгсөн, өгч байна. Зөвлөлтийн академич И.Ш.Майский Чингис хааныг байлдан дагуулагч, улс орны соёл эдийн засгийг сүйтгэн сөнөөгч мэтээр дүгнэсэн мэргэжлийн биш гэлтэй урт өгүүлэл нийтлүүлсэн юм... БНМАУ-ын "Үнэн" сонины 1962 оны 5-р сарын 31-ний дугаарт "Анхны Монгол улсыг үндэслэн байгуулагч" нэртэй том тэргүүн өгүүлэл нийтлэгдсэн. Зохиогч нь Түүхийн хүрээлэнгийн захирал, академич Ш.Нацагдорж байсан юм. Зохиогч хэдийгээр гадна дотны хатуу дарамтад байсан хэдий ч Чингис хааны ролийг эрхбиш зөв талаас нь дүгнэхийг хичээсэн харагддаг. Тухайн үед Хятадын түүхчин Хан Жулинь Чингис хааны түүхэн ролийн талаар чамбай өгүүлэл нийтлүүлж, Чингисийн түүхэн ролийг эерэг, сөрөг хоёр талаар дүгнэн бичсэн юм. Энэ гурван эрдэмтний бичсэн өгүүллийг харьцуулан уншихад л тухайн үед Чингисийн талаар гурван улсын эрдэмтдийн үзэл баримтлалыг амархан мэдэж болно гэх мэтээр бичжээ.

Ян На-гийн зохиолыг уншихад санаа нийлэмгүй зарим нэг нотолгоо дүгнэлт үзэгдэж л байна. Тухайлбал Чингис хааны их Монгол Улсыг байгуулах үед монголчууд бичиг үсэггүй байгаад, дараа нь уйгар бичиг хэрэглэсэн гэх мэт. Гэтэл манай Монгол улсын эрдэмтэд уйгаржин монгол бичгийг 13 зуунаас бүр өмнө авч хэрэглэсэн. Чингис хаан бичиг мэддэг хүн байсан. "Монголын нууц товчоо" гэдэг алдарт зохиолыг тэр үед монголоор бичсэн гэх мэтээр ярьж бичдэг билээ.

Эцэст нь БНХАУ-ын эрдэмтэн Ян На-гийн энэхүү зохиол нь сүүлийн үед хятадад гарсан монголын түүхийн шинэлэг бүтээл гэж үзэж болох юм. Иймээс Ян На-гийн зохиолыг монголоор орчуулж монголын уншигч олонд

---

хүргэх нь зүйтэй мэт санагдана.

Номын зохиогч Ян На 1935 онд Шанхайд төрсөн. 1958 онд Бээжин их сургууль төгссөн. Юан гүрний түүх буюу эртний хятад сурвалж бичиг, архивын материалыг анхааран судалдаг. Юан гүрний үеийн хятадын тариачдын бослого, тариачдын бослогод шашны гүйцэтгэсэн ролийг судалж ном зохиол бичжээ. Нэг хэсэгтээ Бээжин номын сангийн орлогч захиралаар ажиллаж байгаад эдүгээ тэтгэвэрт гарчээ. Гэвч одоо эрдэм шинжилгээний ажлаа идэвхтэй хийсээр байгаа аж.